ДК
"ДЭЛГЭР КОНСАЛТИНГ" ХХК

Улаанбаатар. Бага тойруу-47: Утас: (976)-99194746: E-mail: delgerconsulting@gmail.com

2025 оны 02 сарын 06-ны өдөр Дугаар 1/01 Улаанбаатар хот

**БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХ ТӨСӨЛД**

*Зөвлөх үйлчилгээний гэрээт ажлын гүйцэтгэлийн тайлан хүргүүлэх тухай*

"Байгаль хамгаалагчийн сургалтын хөтөлбөрийн дагуу судалгаа, мониторингийн сургалт зохион байгуулах" (Дугаар: БОЯБХУАӨДЗТөсөл/20240904019) зөвлөх үйлчилгээний гэрээт ажлын гүйцэтгэлийн тайланг холбогдох бусад материалын хамт хүргүүлэв. Үүнд:

1. Гүйцэтгэлийн тайлан (Монгол, Англи хэлээр)
2. Байгаль хамгаалагчийг мэргэшүүлэх анхан шатны сургалтын гарын авлагын хэвлэсэн эх. А4/210 нүүр.
3. Байгаль хамгаалагчийг мэргэшүүлэх дунд шатны сургалтын гарын авлагын хэвлэсэн эх. А4/282 нүүр.
4. Дээрх 2 гарын авлагын эх, түүнд орсон гэрэл зураг, дүрслэл, байгаль хамгаалагчийг мэргэшүүлэх мониторингийн сургалтын хэрэглэгдэхүүнийг тоон хувилбараар буулгаж, хадгалсан зөөврийн зөөврийн диск – 1ш..

УЛААНБААТАР ХОТ ДЭЛГЭР КОНСАЛТИНГ ХХК ТТТ3464 5929849

ЗАХИРАЛ Х. ТЭРБИШ

ДК
"ДЭЛГЭР КОНСАЛТИНГ" ХХК

Улаанбаатар. Бага тойруу-47: Утас: (976)-99194746: E-mail: delgerconsalting@gmail.com

2025 оны 02 сарын 25 ны өдөр Дугаар 1/02 Улаанбаатар хот

**БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХ ТӨСӨЛД**

*Зөвлөх үйлчилгээний гэрээт ажлын гүйцэтгэлийн шинэчилсэн тайлан, холбогдох материалыг хүргүүлэх тухай*

"Байгаль хамгаалагчийн сургалтын хөтөлбөрийн дагуу судалгаа, мониторингийн сургалт зохион байгуулах" (Дугаар: БОЯБХУАӨДЗТөсөл/20240904019) зөвлөх үйлчилгээний гэрээт ажлын гүйцэтгэлийн тайланг хүлээн авах ажлын хэсгийн гишүүдээс бичгээр ирүүлсэн асуулт, санал, шүүмжийн дагуу Байгаль хамгаалагчдыг мэргэшүүлэх анхан ба дунд шатны сургалтын нэмэн боловсруулж баяжуулсан гарын авлагын эх зохиолыг түүнд холбогдох сургалтын бусад материалын хамт хүргүүлэв. Үүнд:

1. Гүйцэтгэлийн тайлан (Монгол, Англи хэлээр), хавсралтын хамт (Хавсралт 1-10)
2. "Байгаль хамгаалагчийн сургалтын хөтөлбөрийн дагуу мониторингийн мэргэшүүлэх сургалт зохион байгуулах" сэдэвт гэрээт ажлын гүйцэтгэлийн тайлантай холбогдож гарсан саналын товъёог (Хавсралт 11).
3. Байгаль хамгаалагчийг мэргэшүүлэх анхан шатны сургалтын гарын авлагын хэвлэсэн эх. A4/215 нүүр.
4. Байгаль хамгаалагчийг мэргэшүүлэх дунд шатны сургалтын гарын авлагын хэвлэсэн эх. A4/284 нүүр.
5. Дээрх 2 гарын авлагын эх, түүнд орсон гэрэл зураг, дүрслэл, байгаль хамгаалагчийг мэргэшүүлэх мониторингийн сургалтын хэрэглэгдхүүн, видео бичлэг зэрэг нийт 869 MB багтаамжтай материалыг тоон хувилбараар буулгаж, хадгалсан зөөврийн диск – 1ш.

УЛААНБААТАР ХОТ
ДЭЛГЭР КОНСАЛТИНГ ХХК
ТТТ3464 5929849

ЗАХИРАЛ Х. ТЭРБИШ

# "БАЙГАЛЬ ХАМГААЛАГЧИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ДАГУУ СУДАЛГАА, МОНИТОРИНГИЙН СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ" (БОЯБХУАӨДЗТөсөл/20240904019/01/02) ГЭРЭЭТ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Улаанбаатар**
**2025 оны 02 сарын 03**

ОРШИЛ

"Байгаль хамгаалагчийн сургалтын хөтөлбөрийн дагуу судалгаа, мониторингийн сургалт зохион байгуулах" зөвлөх үйлчилгээний ажлыг 2024 оны 10 сарын 10-аас 2025 оны 02 сарын 10-ий өдрүүдэд талуудын хооронд байгуулсан гэрээний дагуу гүйцэтгэв. БОУАӨЯ-ны Төрийн бичгийн даргын баталсан ажлын даалгавар, Захиалагч болон Санхүүжүүлэгч талтай гэрээгээр харилцан тохиролцсоны дагуу зөвлөх үйлчилгээний ажлын хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлыг тайлагнаж байна.

**Гүйцэтгэгч баг хамт олон.** Сургалтын гарын авлагын эх эмхэтгэн зохиох, нийцлийн сургалт зохион байгуулах ажлыг дараах бүрэлдэхүүнтэй баг хамт олон гүйцэтгэв. Үүнд:

1. Х.Тэрбиш - Багийн ахлагч. МУИС-ийн зөвлөх профессор, доктор (PhD) биологич, экологич.
2. С.Шар – Багийн гишүүн. МУИС-ийн зөвлөх дэд профессор, доктор (PhD) биологич, амьтан судлаач.
3. Д.Лхагвасүрэн – Багийн гишүүн. МУИС-ийн дэд профессор, доктор (PhD), биологич-амьтан судлаач, экологич.
4. Д.Нарангарвуу - Багийн гишүүн. МУИС-ийн дэд профессор, доктор (PhD), биологич-амьтан судлаач, экологич.
5. Д.Өсөхжаргал - Багийн гишүүн. МУИС-ийн ахлах багш, доктор (PhD), биологич-амьтан судлаач, байгаль хамгааллын биологич.
6. Ц.Сэр-Од - Багийн гишүүн. МУБИС-ийн багш, доктор (PhD), Газар зүйч, аялал жуулчлалын менежер.
7. А.Ариунжаргал - Багийн гишүүн. МУБИС-ийн багш, доктор (PhD), Сургалтын онол арга зүйч
8. М.Эрдэнэбаяр - Багийн гишүүн. Олон улсын Улаанбаатар их сургуулийн Хуулийн тэнхимийн багш, профессор, доктор (PhD), цагдаагийн хурандаа, Экологийн эрх зүйч
9. Д.Бадамцэцэг - Багийн гишүүн. ДХИС-ийн Экологийн эрх зүйн тэнхимийн ахлах багш, доктор (PhD), цагдаагийн дэд хурандаа, Экологийн эрх зүйч.
10. С.Даваацэрэн – Багийн гишүүн. ОБЕГ-ын Санхүү ар талын газрын ахлах шинжээч, онцгой байдлын албаны ахмад, Хүний их эмч, анагаах ухааны магистр.
11. Г.Ууганбаяр – Хустайн БЦГ-ын Хамгаалалтын захиргааны судалгаа, хамгаалал хариуцсан мэргэжилтэн, биологийн ухааны магистр.

# НЭГ. БАЙГАЛЬ ХАМГААЛАГЧИЙГ МЭРГЭШҮҮЛЭХ АНХАН БА ДУНД ШАТНЫ СУРГАЛТЫН ГАРЫН АВЛАГА БОЛОВСРУУЛСАН АЖЛЫН ТАЛААР

Баталсан сургалтын хөтөлбөрийн дагуу "Байгаль хамгаалагчийг мэргэшүүлэх анхан шатны сургалтын гарын авлага"-ын эхийг 5 бүлэг, сэдвийг хамран боловсруулсан болно. Сургалтын модулийн үндсэн агуулгыг 1-р хавсралтаар үзүүлэв. Мөн уг гарын авлагыг бүрэн эхээр нь хэвлэмэл болон тоон (дижитал) хэлбэрээр энэ тайланд хавсаргалаа. Гарын авлагын эх бичвэр нь 5 бүлэг, 130 гаруй сэдвийг хамарсан, А4 хэмжээтэй 210 гаруй нүүр бөгөөд 174 зураг, бүдүүвч, гэрэл зураг, 18 хүснэгт, суралцагсдын мэдлэг сорих 140 тест, ахиц дэвшлийг үнэлэх 30 тест, бүгд 170 тест, асуулт-51, даалгавар, дадлага ажил-23, бие даалтын сэдэв-16, жишээ-10, ном бүтээлийн жагсаалт, хавсралт зэргээс бүрдэл болно. Эхэд орох зургуудыг бүлэг тус бүрээр ялган, тус тус тоон хавтсанд оруулж эмхлэв. Мөн анхан шатны сургалтанд зориулан 15 иж бүрдэл хичээлийн хэрэглэгдэхүүн боловсруулж, мониторингийн сургалтанд ашигласан.

БОУАӨЯ-аас өгсөн чиглэл, зөвлөмжийн дагуу, АНУ-ын ХААЯ-ны Ойн албанаас Монгол улсад хэрэгжүүлж буй "Зэрлэг амьтан, ургамлын эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний чадавхыг бэхжүүлэх нь" төслөөс боловсруулсан эргүүл хяналтын ажлын арга, техникийн асуудлыг Байгаль хамгаалагчдыг мэргэжүүлэх анхан шатны сургалтын гарын авлагын 4-р бүлэгт "4.3. Эргүүл, хяналт шалгалтын зарим арга, анхаарах зүйлс" гэсэн дэд сэдэв болгон нэмж оруулав.

"Байгаль хамгаалагчийг мэргэшүүлэх дунд шатны сургалтын гарын авлага"-ын эх зохиолыг сургалтын хөтөлбөрийн дагуу 5 бүлгээр, 2-р хавсралтад буй агуулгыг хамран боловсруулсан болно. Гарын авлагын эх бичвэр нь эдгээр 5 бүлгийн 80 гаруй сэдвийг хамарсан, А4 хэмжээтэй 280 гаруй нүүр бөгөөд 160 төрөл бүрийн зураг, бүдүүвч, гэрэл зураг, 43 хүснэгт, суралцагсдын мэдлэг сорих 140 тест, ахиц дэвшлийг үнэлэх 30 тест, нийт 170 тест (хариултын хамт), асуулт-26, даалгавар, дадлага ажил-24, бие даалтын 25 сэдэв болон бүтээлийн жагсаалт, хавсралт зэргийг багтаажээ.

Бүлэг, сэдвийн агуулгыг баяжуулж утга санааг бүрэн илэрхийлэх, суралцагсдад ойлгомжтой болгох үүднээс БИОСАН, СМАРТ, BAIGALI программуудын ажлын хуудаснууд, тэдгээрийн ухаалаг утасны дэлгэцэд харагдах байдал зэргийг харуулсан зураг зэрэг нийт 30 гаруй зураг, дүрслэлийн материалыг эдгээр гарын авлагад оруулав. Уг зураг, дүрслэлийн материалууд нь эх бичвэрт зохих журмын дагуу ишлэгдсэн, эсвэл зохиогчид нь өөрсдийн гэрэл зургийн бүтээлээ ашиглахыг зөвшөөрч, албан ёсоор эх хувиар нь өгсөн тул зохиогчийн эрхийн хувьд ямар нэг асуудалгүй болохыг дашрамд тэмдэглэе.

Багш бүр өөр өөрсдийн боловсруулсан бүлэг, сэдвийн дагуу 16 иж бүрдэл сургалтын материал болон цогц слайд бэлтгэж, сургалтад ашиглахад бэлэн болгосны зэрэгцээ мониторингийн сургалтад түүнийгээ ашиглан хичээл заалаа.

Эшилсэн болон суралцагсдын ашиглах бүтээлийн жагсаалтыг тогтсон журмын дагуу бүлэг тус бүрээр үйлдэж, тухайн бүлгийн төгсгөлд оруулав.

## ХОЁР. БАЙГАЛЬ ХАМГААЛАГЧИЙГ МЭРГЭШҮҮЛЭХ АНХАН БА ДУНД ШАТНЫ МОНИТОРИНГИЙН СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛСАН ТАЛААР

**Сургалтын бэлтгэл ажил** Сургалтыг хэзээ, хэрхэн зохион байгуулах болон сургалтад хамрагдлах байгаль хамгаалагчдын асуудлыг БОУАӨЯ, "Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох II, III" төслийн нэгжид тухай бүрд албан ёсоор танилцуулан чиглэл, зөвлөгөө авч, холбогдох Тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаанд албан бичиг хүргүүлэх, сертификатын эх бэлтгэх, хэвлүүлэх зэргээр зохих бэлтгэл ажлыг хангав. Мөн Монгол улсын Засгийн газрын тохируулагч агентлаг - ОБЕГ, МУИС, МУБИС, ДХИС-д холбогдох мэргэжлийн багш нарыг Байгаль хамгаалагчдын мэргэшүүлэх сургалтанд оролцуулах асуудлыг гүйцэтгэгчийн зүгээс албан бичгээр тавьж шийдвэрлүүлэв. Сургалтад оролцогсдын байр, хоол, унаа тээврийн асуудлыг Хустайн БЦГ төв төрийн бус байгууллага болон холбогдох бусад газартай зөвшилцөн зохицуулав.

**Сургалтанд оролцсон байгаль хамгаалагчдын мэргэжил, боловсрол, ажлын туршлага.** БОУАӨЯ-ны Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлогын хэрэгжилтийн газрын хуваарийн дагуу энэ удаагийн сургалтад Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 6, Богдхан уулын дархан цаазат газар, Хан Хэнтийн дархан цаазат газар, Хустайн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаанаас тус тус 3, нийт 15 байгаль хамгаалагчид оролцов (3-р хавсралт).

Сургалтад хамрагдсан 10 байгаль хамгаалагч нь дээд, 1 нь тусгай дунд (цахилгаанчин), 4 нь бүрэн дунд боловсролтой хүмүүс байв. Дээд боловсролтой байгаль хамгаалагчдаас 5 хүн экологич, байгаль хамгаалагч мэргэжлээр суралцаж төгссөн бол өрмийн инженер, эрх зүйч, малын их эмч, аялал жуулчлалын мэргэжилтэн, эдийн засагч мэргэжилтэй тус бүр 1 хүн байна.

Байгаль хамгаалагчийн албан тушаалд 0,1-2 жил ажиллаж байгаа 6; 5-10 жил ажиллаж буй – 6; 25-29 жил ажиллаж буй – 2 хүн тус тус энэ удаагийн сургалтад оролцлоо.

**Сургалтын зохион байгуулалт, явц, багшлах бүрэлдэхүүн.** Байгаль хамгаалагчийг мэргэшүүлэх анхан ба дунд шатны мониторингийн сургалтыг 2025 оны 1 сарын 13-наас 17-ны өдрүүдэд Хустайн байгалийн цогцолборт газарт 5 хоног байрлаж зохион байгууллаа.

Манай орны их дээд сургуулийн сургалтын практикаар шалгагдаж тогтсон жишгийн дагуу энэ удаагийн нийцлийн сургалтын хичээлийн хуваарийг боловсруулж мөрдөв. Тодруулбал, байгаль хамгаалагчийг мэргэшүүлэх анхан ба дунд шатны сургалтын 2 цагийн багтаамжтай нэгж хичээлийн үргэлжлэх хугацааг 90 минутаар тооцон хичээлийн хуваарийг боловсруулав. Хичээл хоорондын завсарлага 20 минут, үдийн их завсарлага 60 минут байхаар тус тус төлөвлөсөн. Багш бүр цагийн менежментийг сайн хэрэгжүүлсэн.

Анхан шатны мэргэшүүлэх сургалтад 9 байгаль хамгаалагч, дунд шатны сургалтад 6 байгаль хамгаалагч хамрагдан суралцаж, нэр бүхий 9 багш хуваарьт хичээлийг заалаа. Мониторингийн сургалтад, баталсан хөтөлбөр болон боловсруулсан сургалтын модулийн дагуу анхан шатны 40 цаг, дунд шатны 40 цагийн багтаамжтай хичээлийг, урьдчилан боловсруулсан хуваарийн дагуу орсон (4-р хавсралт). Сургалтын хөтөлбөрт тусгагдсан сэдвүүдээр мэргэшсэн, эрдмийн

зэрэг цолтой, Монгол улсын их дээд боловсрол, шинжлэх ухааны салбарт олон арван жил ажиллаж туршлагажсан дээрх нэр бүхий багш нар суралцагчдад хичээлийг заалаа.

Монгол улсын онцлогийг тусган боловсруулж, Галбын говийн бүс нутгийн байгаль, зэрлэг амьтдын судалгаанд тодорхой хугацаанд туршин хэрэгжүүлэх ажлыг удирдан гүйцэтгэсэн, Зэрлэг амьтан хамгаалах, судлах төвийн ажилтан (WCS) Б.Нарангуаг урьж, дунд шатны мэргэшүүлэх сургалтад СМАРТ программын хичээл заалгалаа. Энэ сэдвээр явуулсан сургалтад Хустайн БЦГ-ын хамгаалалтын захиргааны хүсэлтээр тэндхийн 7 байгаль хамгаалагчийг нэмж оролцуулан, өргөтсөн хэлбэрээр хичээлийг зохион байгуулав.

Сургалтыг лекц, дадлага хослуулан явуулахдаа агуулгын 30 хувьд онолын мэдлэг, 70 хувьд дадлага хийлгэхээр төлөвлөж, ажлын 5 өдөр хичээллэв. Сургалтад төрөл бүрийн гэрэл зургийн аппарат, 200-400 мм-ийн татдаг дуран, гэрэл зургийн автомат камер -3 иж бүрдэл, янз бүрийн машстабын газрын зураг, дуран, байршил тогтооч (GPS) -3ш, зай хэмжигч 2 ш, луужин, амьд баригч, радио дамжуулагч бүхий төрөл бүрийн размерын хүзүүвч -3ш, луужин, DJI Mavic pro загварын нисгэгчгүй нисэх төхөөрөмж (ННТ буюу дрон), ургамлын гербари, төрөл бүрийн видео бичлэг зэргийг ашиглан дадлага хичээлийг явуулլаа.

Сургалтын төгсгөлд БОУАӨЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын гарын үсэг бүхий, төрийн яамны тамгаар баталгаажуулсан мэргэшүүлэх сургалтын сертификатыг байгаль хамгаалагчдад олгосон (5-р хавсралт). Анхан шатны сургалтад хамрагдагсдад 25/A01-ээс 25/A9 хүртэлх дугаартай, дунд шатны сургалтад хамрагдагсдад 25/B01-ээс 25/B6 хүртэлх дугаартай сертификатуудыг тус гардуулав. Сертификатын дугаарын тайллыг 25/A01 ба 25/B01 гэсэн дугаартай сертификатаар жишээлэн авч үзье. Үүнд:

25 – Сургалт 2025 онд болсныг,

A – Анхан шатны мэргэшүүлэх сургалтад суралцсан болохыг,

B - Дунд шатны мэргэжүүлэх сургалтад суралцсан болохыг,

01 – гэсэн цифр нь тухайн суралцагчид олгосон сертификатын дугаарыг тус тус илэрхийлнэ.

Сургалтад хамрагдсан байгаль хамгаалагч тус бүрд сургалтын багц хэрэглэгдэхүүн тавьж олгосон. Сургалтын үйл ажиллагааг харуулсан зарим гэрэл зургийг 10-р хавсралтаас үзнэ үү.

**Сургалтын явцын хяналт.** Сургалтын явц, үйл ажиллагаанд БОУАӨЯ-ны ажлын хэсгийг төлөөлж, Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төслийн ахлах зөвлөх, доктор П.Галрагчаа, нэгжийн гэрээ хариуцсан мэргэжилтэн М.Амгалан болон Монголын байгаль хамгаалагчдын холбооны гүйцэтгэх, доктор С.Баярхүү нар оролцож санал зөвлөмж өгсөн.

Энэ удаагийн сургалт урьдчилан төлөвлөсөн хуваарийн дагуу ямар нэг алдаа мадаггүй явагдсан бөгөөд сургалтын технологийг өндөр дээд түвшинд мөрдөн хэрэгжүүлсэн хэмээн гүйцэтгэгчийн зүгээс үзэж байна.

**Сургалтын хэрэглэгдэхүүн.** Сургалтад зураг, бүдүүвч, хэвлэмэл хуудас, видео бичлэг, слайд, төрөл бүрийн багаж хэрэгсэл, тоног, төхөөрөмж, ургамлын хатаамал цуглуулга зэрэг биет хэрэглэгдэхүүний зэрэгцээ бүлэг, сэдэв тус бүрээр нийт 31 сэдэвчилсэн цогц дижитал хэрэглэгдэхүүнийг (анхан шат-15, дунд шат -16) бэлтгэж ашиглав. Тэдгээр сургалтын хэрэглэгдэхүүнийг дижитал хэлбэрээр эх хувиар нь төслийн нэгжид хүргүүлсэн болно.

**Сургалтын ахиц, дэвшлийн үнэлгээ.** Урьдчилан боловсруулсан тестээр (6-р хавсралт) сургалтын эхэнд болон сургалтын дараа суралцагчдын мэдлэгийг сорьж, ахиц дэвшлийн төлөв байдалд үнэлгээ өгөх оролдлого хийв. Анхан шатны сургалтад оролцсон 9 байгаль хамгаалагч сургалтын эхэнд давхардсан тоогоор 270 асуултаас 102 асуултад зөв хариулж 37,8% байсан бол сургалтын дараа 150 асуултад зөв хариулж 55,6% болон мэдлэгийн түвшин 17,8 хувиар өссөн үр дүн гарсан. Дунд шатны сургалтад оролцсон 6 байгаль хамгаалагч сургалтын эхэнд давхардсан тоогоор 180 асуултаас 107-г зөв хариулж 59,8%, харин сургалтын дараа 125 асуултыг зөв хариулж 69,4% болон мэдлэгийн түвшин 10 хувиар нэмэгдсэн байдалтай байна (Хүснэгт 1).

ХҮСНЭГТ 1. БАЙГАЛЬ ХАМГААЛАГЧДЫГ МЭРГЭШҮҮЛЭХ МОНИТОРИНГИЙН СУРГАЛТАД ОРОЛЦОГСДЫН АХИЦ ДЭВШЛИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

| № | Байгаль хамгаалагчдын нэрс | Аввал зохих | | Сургалтын эхэнд | | Сургалтын дараа | | Ахиц дэвшлийн төлөв, хувиар |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | оноо | Хувь | Оноо | Хувь | Оноо | Хувь | |
| **Анхан шат** | | | | | | | | |
| 1 | А.Амармэнд | 30.0 | 100.0 | 16.0 | 53.3 | 18.0 | 60.0 | 6.7 |
| 2 | Гэлэгжамц | 30.0 | 100.0 | 9.0 | 30.0 | 16.0 | 53.3 | 23.3 |
| 3 | М.Мэндсайхан | 30.0 | 100.0 | 13.0 | 43.3 | 17.0 | 56.7 | 13.3 |
| 4 | Ариунболд | 30.0 | 100.0 | 13.0 | 43.3 | 17.0 | 56.7 | 13.3 |
| 5 | Сансар | 30.0 | 100.0 | 13.0 | 43.3 | 18.0 | 60.0 | 16.7 |
| 6 | Т.Шижирбаатар | 30.0 | 100.0 | 6.0 | 20.0 | 17.0 | 56.7 | 36.7 |
| 7 | Амартүвшин | 30.0 | 100.0 | 2.0 | 6.7 | 10.0 | 33.3 | 26.7 |
| 8 | Э.Эрдэнэболд | 30.0 | 100.0 | 15.0 | 50.0 | 18.0 | 60.0 | 10.0 |
| 9 | Б.Ганболд | 30.0 | 100.0 | 15.0 | 50.0 | 19.0 | 63.3 | 13.3 |
| | Нийт | 270.0 | 100.0 | 102.0 | 37.8 | 150.0 | 55.6 | 17.8 |
| **Дунд шат** | | | | | | | | |
| 1 | С.Баасанхорол | 30.0 | 100.0 | 17.0 | 56.7 | 21.0 | 70.0 | 13.3 |
| 2 | О.Пүрэврагчаа | 30.0 | 100.0 | 17.0 | 56.7 | 22.0 | 73.3 | 16.7 |
| 3 | Н.Оюундаваа | 30.0 | 100.0 | 23.0 | 76.7 | 24.0 | 80.0 | 3.3 |
| 4 | Д.Болд-Эрдэнэ | 30.0 | 100.0 | 17.0 | 56.7 | 19.0 | 63.3 | 6.7 |
| 5 | Б.Буджав | 30.0 | 100.0 | 18.0 | 60.0 | 22.0 | 73.3 | 13.3 |
| 6 | С.Содов | 30.0 | 100.0 | 15.0 | 50.0 | 17.0 | 56.7 | 6.7 |
| | Бүгд | 180.0 | 100.0 | 107.0 | 59.4 | 125.0 | 69.4 | 10.0 |

**Сургалтын талаарх байгаль хамгаалагчдын санал, дүгнэлт.** Анхан болон дунд шатны сургалтад хамрагдсан 15 байгаль хамгаалагч, Хустайн байгалийн

цогцолборт газрын 5 байгаль хамгаалагчийг оролцуулан энэхүү сургалтын талаарх сэтгэл ханамжийн судалгааг авсан. Сургалтыг явуулж байгаа багш нарын хичээл заах арга барил, хичээлийн бэлтгэл, хэрэглэгдэхүүн, суралцагчтай харилцах харилцааны байдлаар асуулга авахад Сургагч багш нарын ур чадварыг 45 удаа маш сайн, 35 удаа сайн гэж дүгнэсэн байна (График 1, 7-р хавсралт).




График 1.Сургагч багш нарын ур чадварын үнэлгээ

Сургалтад оролцогчдоос сургалтын зорилгоо биелүүлсэн байдал, сэдвийн агуулгын эрэлт хэрэгцээг тандсан санал асуулгад 19 оролцогч сайн, маш сайн, 1 оролцогч хангалтгүй гэсэн үнэлгээ өгсөн (График 2).

Байгаль хамгаалагчдаас авсан сургалтын үргэлжлэх хугацааны талаарх санал асуулгын дүнгээс үзвэл 90% хувь нь сургалт үргэлжлэх хугацааг зохимжтой, 5% нь хэт богино, 5% нь хэт урт гэж үзжээ (График 3).






График 2.Сэтгэл ханамжийн байдал    График 3.Сургалтын үргэлжлэх хугацаа

**Бусад зүйлс**

1. Сургалтын хугацаанд багш нар, байгаль хамгаалагчид, жолооч нарын байр, хоол, цай кофе зэрэг үйлчилгээг сэтгэл зүтгэл гарган чанарын өндөр дээд түвшинд үзүүлж, хичээлийн танхим, тоног төхөөрөмж, техник хэрэгслээр бүрэн хангасан Хустайн БЦГ төвийн хамт олон, захирал Ц.Дашпүрэвт гүнээ талархаж байна.
2. Хустайн БЦГ-ын Хамгаалалтын захиргаа, энд ажиллаж байсан, ажиллаж байгаа хамт олны 30 гаруй жилийн турш хийж хэрэгжүүлсэн байгаль хамгааллын олон талт үйл ажиллагаа, хичээл зүтгэлийн үр дүнтэй танилцах богино хугацааны экскурсийг сургалтын төгсгөлийн өдөр сургалтад оролцогсдын бүрэн бүрэлдэхүүнээр зохион байгуулав. Экскурсийн хугацаанд энэ тусгай хамгаалалттай газрын нутаг дэвсгэрт сэргээн нутагшиж буй тахь, халиун буга, цагаан зээрийн өнөр өтгөн сүргүүдтэй алхам тутамд таарч, тэдний эрх дураараа, амар амгалан идээшин амьдарч байгааг үзэж танилцав. Сургалтад оролцсон байгаль хамгаалагчдын маань хувьд сэтгэл тун хангалуун, бас ч зарим нь атаархангуй байсныг дурдсуу.
3. Сургалтад хичээл заасан ОБЕГ-ын ахлах шинжээч, хүний их эмч, ахмад С.Даваацэрэн, сургалтад оролцсон болон Хустайн БЦГ-ын хамгаалалтын захиргааны байгаль хамгаалагчид зэрэг нийт 30 шахам хүнд анхан шатны эмчийн үзлэг хийв. Тэрээр энэ ажлыг санаачлан, зүрхний цахилгаан бичлэгийн аппарат болон бусад тоног, хэрэгслээ бэлдэж ирсэн нь нэн сайшаалтайн зэрэгцээ, хүн ардын эрүүл энхийн төлөө өргөсөн тангаргаа хаана ч, ямар ч нөхцөлд чандлан сахиж, даган мөрдөж хөдөлмөрлөдгийнх нь нэгээхэн илрэл юм даа.
4. Эмчийн анхан шатны үзлэгээр сургалтад оролцсон нийт байгаль хамгаалагчдын 86,6 хувийнх нь зүрх, судасны үйл ажиллагааны үзүүлэлт хэвийн бус, артерийн даралт өндөр (140/100mmHg – 180/120mmHg) гэсэн үзүүлэлттэй байна (9-р хавсралт).
5. Гэрээт ажлын гүйцэтгэлийн тайланг хэлэлцсэн ажлын хэсгийн гишүүдээс бичгээр ирүүлсэн асуулт, санал, шүүмжийг хэрхэн хүлээж авсан тухай дэлгэрэнгүй танилцуулгыг энэхүү тайланд хавсаргав (11-р хавсралт).

**ДҮГНЭЛТ**

1. Байгаль хамгаалагчдыг мэргэшүүлэх анхан ба дунд шатны сургалтын хөтөлбөрийн агуулга нь байгаль хамгаалагчдын эрэлт хэрэгцээнд бүрэн нийцсэн, тэдний цаашдын ажилд үр дүнгээ өгөхүйц хэмжээнд боловсрогдсон байна.
2. Анхан ба дунд шатны сургалтын хөтөлбөрийн агуулга нь төлөвлөсөн цагийн хэмжээнд бүрэн тохирч байна.
3. Анхан ба дунд шатны мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийн агуулгын дагуу гүйцэтгэгч баг хамт олны боловсруулсан сургалтын модуль нь уг сургалтын шаардлагад бүрэн нийцэж байна хэмээн бид үзлээ.
4. Сургалтад оролцогчдоос авсан сэтгэл ханамжийн судалгааны дүнгээс үзвэл 95 хувь нь зорилгоо ханган биелүүлсэн, үр дүнтэй сургалт боллоо хэмээн үнэлсэн

нь гүйцэтгэгч багийн ажилд өгсөн бодит үнэлгээ хэмээн үзэх бүрэн үндэстэй байна.

5. Сургалтад оролцогсдын мэдлэгийн түвшин, сургалтын өмнөх үеийнхээс 27,8 хувиар нэмэгдэж, тодорхой ахиц, дэвшил гарсныг энэ удаагийн мониторингийн сургалтын нэг үр дүн хэмээн үзэж байна.
6. Байгаль хамгаалагчийг мэргэшүүлэх сургалтыг 15-20 хүнтэй бүлгээр зохион байгуулах нь илүү үр дүнтэй болно.

**САНАЛ**

Сургалтын гарын авлага боловсруулж, мониторингийн сургалт зохион байгуулах явцад анзаарагдсан зарим зүйлийг засч сайжруулах нь зүйтэй хэмээн үзэж байна. Үүнд:

1. Анхан шатны мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийн 3 дахь хэсэг буюу "Аюулгүй ажиллагаа, анхан шатны тусламжийн тухай" бүлгийн "Зүрхний даралт болон зүрхний шигдээсний үед үзүүлэх анхны тусламж" гэсэн агуулгын нэрийг "Цусны даралт болон зүрхний шигдээсний үед үзүүлэх анхны тусламж" хэмээн өөрчлөн нэрлэх нь зүйтэй байна. Бид мониторингийн сургалтыг энэ нэршлээр зохион байгуулсны зэрэгцээ сургалтын гарын авлагад ч бас тусгасан.
2. Дунд шатны мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрт орсон СМАРТ арга зүйн 16 цагийн хичээлийг туршилтын байдлаар зааж дараах нэмэлт өөрчлөлтийг сургалтын хөтөлбөрт оруулах зайлшгүй шаардлагатай гэж үзлээ. Тухайлбал, СМАРТ арга зүйг ТХГ-ийн хамгаалалтын захиргааны мэргэжилтэн ба байгаль хамгаалагчид гэсэн өөр хоорондоо ялгаатай үндсэн 2 чиг үүргийн ажилтнуудад зориулан боловсруулсан байна. Ийм учраас цаашдаа СМАРТ арга зүйн сургалтыг тус тусдаа ялгавартай 2 агуулгаар зохион байгуулах шаардлагатай болж байна. Үүнтэй уялдан байгаль хамгаалагчдын сургалтын хөтөлбөрт буй СМАРТ аргазүйн агуулгаас мэргэжилтэнд орох хэсгийг хасаж, агуулгыг 8-р хавсралтын дагуу өөрчлөн 14 цагт багтаан судлахыг санал болгож байна.
3. Байгаль хамгаалагч нь ажилдаа орсон цагаас эхлэн СМАРТ аргазүйг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэглэж, хуулийн хэрэгжилтийг сахин биелүүлэх үүрэгтэй тул уг агуулгыг "анхан шат"-ны сургалтын агуулгад тусган хэрэгжүүлэх боломжийг судалж үзэх шаардлагатай.
4. Гурван түвшний шаталсан сургалтанд байгаль хамгаалагчдаа ямар хуваариар, хэзээ хамран сургах тухай саналыг Тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаанд нарийвчлан гаргасны үндсэнд улсын хэмжээнд байгаль хамгаалагчдыг мэргэшүүлэх сургалтын нэгдсэн хуваарийг Монголын байгаль хамгаалагчдын холбоо боловсруулан, БОУАӨЯ-тай зөвшилцөж хэрэгжүүлэхийг зөвлөмжилж байна.
5. МУИС-ийн ШУС-ийн Биологийн тэнхмийг түшиглэн Байгаль хамгаалагчдын мэргэшүүлэх сургалтын сургагч багш нарыг мэргэшүүлэн бэлтгэх арга хэмжээг 2025 онд багтаан хэрэгжүүлэх саналтай байна.
6. Байгаль хамгаалагчдын мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийн дагуу боловсруулсан сургалтын гарын авлага, тест, төрөл бүрийн зураг, диаграмм, график, асуулт, даалгавар, дасгал ажил, жишээ, ювидео бичлэг зэрэгт тулгуурлан уг сургалтын цахим хувилбарыг бүтээх ажлыг 2025-2026 онд хэрэгжүүлэхийг зөвлөж байна.
7. МУИС-ийн Байгалийн ухааны сургуулийн сургалт, судалгааны ажилд ашигладаг багаж, тоног төхөөрөмжийг бид энэ удаагийн мониторингийн сургалтад

ашиглалаа. Цаашдаа энэ сургалт нь цувралаар зохион байгуулагдаж нийт байгаль хамгаалагчдыг хамран сургах зорилготой тул эдгээр сургалтад зориулж сургалтын хэрэглэгдэхүүн, багаж төхөөрөмжийн бааз суурийг бүрдүүлэх шаардлагатай хэмээн үзэж, үүнийг санал болгож байна.

8. Сургалтын явцад багш анхны тусламж үзүүлэх багаж тоног төхөөрөмж, үзүүлэн материалыг биетээр болон зургаар, видеогоор танилцуулсан. Дадлагын явцад тэдгээрийг хэрхэн ашиглаж өөрийнхөө болон бусдын амь нас, эрүүл мэндийг хамгаалах арга, техникт байгаль хамгаалагчид суралцсан. Цаашид байгаль хамгаалагчдыг ажлын байран дээрээ анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх дадлагыг тогтмол давтамжтай хийх нөхцөлөөр хангах шаардлагатай байна. Дашрамд дурьдахад энэ ажлыг Тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаад дотоод нөөц боломжоо ашиглан хэрэгжүүлэх бүрэн боломжтой бөгөөд гагцхүү багахан санаачлага гаргахад л болох үндэстэй.
9. Байгаль хамгаалагчид албан үүрэгт ажлаа эрхлэн гүйцэтгэж байхдаа сэтгэл зүйн дарамтад орох эрсдэлтэй нөхцөл байдалд хүрч болохуйц төлөв байдал энэ удаагийн сургалтын явцад ажиглагдсан нь цаашид байгаль хамгаалагчдын ажлын байрны стресс дарамтыг багасгахад чиглэсэн сэтгэлзүйн хичээлийг оруулах, тэдний эрүүл мэндийг хамгаалах асуудлыг нэн тэргүүнд авч үзэх шаардлагатай болжээ. Учир нь анхан шатны эмчийн үзлэгт хамрагдсан 15 байгаль хамгаалагчийн 2-оос бусад бусдад нь эрүүл мэндийн нарийвчилсан үзлэг, оношилгоонд орох шаардлага үүссэн байна (9-р хавсралт).
10. Анхан шатны сургалтад оролцсон нийт 9 хүн Байгаль хамгаалагчийн ёс зүйн кодыг хүлээн зөвшөөрсөн.

УЛААНБААТАР ХОТ
ДЭЛГЭР КОНСАЛТИНГ ХХК
ТТТ3464 5929849

**ЗАХИРАЛ** **ПРОФЕССОР Х.ТЭРБИШ**

**SUMMARY OF THE CONTRACT PERFORMANCE REPORT OF “ORGANIZING RESEARCH AND MONITORING TRAINING IN ACCORDANCE WITH THE TRAINING PROGRAM FOR RANGERS” (БОЯБХУАӨДЗТӨСӨЛ/20240904019/01/02)**

**05 February 2025** **Ulaanbaatar**

The consultancy service of "Organizing research and monitoring training according to the training program for rangers" was carried out from October 10, 2024 to February 10, 2025, in accordance with the agreement signed between the parties. This is the report about the activities performed within the scope of consulting services negotiated in accordance with the work task approved by the State Secretary of the Ministry of Environment and Climate Change and the mutually agreed upon contract between the Client and Funding Party.

**Executive Team.** The compilation of training book, and organization of corresponding training were performed by the following team members:

1. Kh. Terbish - Team Leader. Consulting Professor of The Mongolian National University, PhD, biologist, and ecologist.
2. S. Shar – Team member. Consulting adjunct professor of the Mongolian National University, PhD, biologist and zoologist.
3. D. Lkhagvasuren – Team member. Adjunct Professor of The Mongolian National University, PhD, biologist-zoologist and ecologist.
4. D. Narangarvuu – Team member. Adjunct Professor of The Mongolian National University, PhD, biologist-zoologist and ecologist.
5. D. Usukhjargal – Team member. Senior Teacher of The Mongolian National University, PhD, biologist – zoologist, conservation biologist.
6. Ts. Ser-Od – Team member. The lecturer at The Mongolian University of Education, PhD, geographer, tour manager.
7. A. Ariunjargal – Team member. The lecturer at The Mongolian University of Education. PhD, educational methodologist.
8. M. Erdenebayar – Team member. Lecturer at the Law Faculty in Ulaanbaatar International University, Professor, PhD, Police Colonel, environmental lawyer.
9. D. Badamtsetseg – Team member. Senior Teacher in the faculty of Environmental Law at The University of Internal Affairs, PhD, Police lieutenant colonel, environmental lawyer.
10. S. Davaatseren – Team member. Senior expert in the finance and logistics department of The Front Office of Emergency Situations, captain of the emergency services, medical doctor, master of medicine.

## 1. ABOUT THE UNDERTAKING PROCESS OF CREATING THE MANUALS FOR BASIC AND INTERMEDIATE LEVELS TRAINING FOR RANGERS

Following the approved training program, the manual for the First Level Training for Rangers was developed covering five main chapters. The text of the manual is more than 200 pages of A4 paper size and with over 80 pictures, diagrams, photos, 18 tables, acquirement test with 140 questions and other tasks and assignments. In accordance with the directions and recommendations by the Ministry of Environment and Climate Change, the procedure of patrol control made out of the project “Strengthening the national capacity of fighting against the crime

of wildlife and natural plants" implemented by The Forestry Service at the Ministry of Agriculture, USA in Mongolia was added as the subtopic. This is in Chapter 4, with the topic of "4.3. Some methods of patrol controls, and considerations" in the textbook for the 1st level training for Rangers.

The textbook for Intermediate level training for Rangers consists of 5 Chapters according to the curriculum. The text of the book is with 270 pages of A4 paper size and has over 130 different pictures, diagrams, photos, 43 tables and acquiring test with 15 questions as well as other tasks and assignments.

The issues regarding to the use of BIOSAN, SMART and BAIGALI programs are also included in details to the manual in order to concentrate the content of the topics, fully express the meaning and make more comprehensive for the students.

Teaching aids and complex slides are prepared by each teacher for the class according to the topics and are used during the monitoring training.

As a rule, bibliography and the list of books to be used by students were made by topics and put at the end of every chapter.

## 2. ORGANIZING BASIC AND INTERMEDIATE MONITORING TRAINING FOR QUALIFICATION OF RANGERS

**Preliminary of the training.** The issues when and how to organize the training, and the rangers who got involved to the training had been presented to The Ministry of Environment and Climate Change and also to the "Biodiversity Protection and Climate Change Adaptation II and III" project units and had been given directions and suggestions from them on time. Also, relevant official documents were sent to the administrations of Specially Protected Areas, and the work to lay out and publish the certificates were prepared in advance to the training process.

The request from the executors to get involved professional teachers to the qualification training for the rangers was officially applied to The Regulatory Agency of the Mongolian Government – The Front Office of Emergency Situations; the Mongolian National University, the Mongolian University of Education, the University of Internal Affairs and the request was successfully solved. The issues regarding to the transportation, accommodation and meals for participants for the training process were solved with the assistance of Khustain National Park - non-government organization and other relevant organizations.

**Profession, education and experience of the rangers involved in training.** 6 from the Administration of protection of Gorkhi-Terelj National Park, 3 from Bogd Khan Mountain Strictly Protected Area, 3 from Khan Khentii Strictly Protected Area and 3 from Khustai National Park, in total 15 rangers were participated in the training, in accordance to the scheduled graphics from Policy implementation department at The Ministry of Environment and Climate Change.

10 rangers have higher education, 1 is with specialized secondary education (electric), 4 rangers have a secondary education. From the higher- educated rangers, 5 have the profession of ecologists and rangers, others have the professions of lawyer, drilling engineer, veterinarian, tourism specialist, and economist.

6 people are working as a ranger for 0.1 – 2 years, 6 people are working for 5-10 years and 2 people are working for 25-29 years.

**Organization, process, and teaching staff.** First and intermediate level monitoring training for qualification of rangers was held from 13 to 17 January, 2025 for 5 days in Khustai National Park.

The duration of one pair and the lesson schedule was operated as 90 minutes. The break between lessons was 20 minutes and the lunch break was 60 minutes. All the teachers had the good time- management.

By the approved programs and training modules first level training had 40 hour lesson in total and intermediate level training had also 40 hour lesson in total, accordingly to the pre-arranged lesson plan. The classes were taught and provided by the above mentioned teachers, who are specialized, graduated and experienced working in the field of higher education system and science for many years.

B. Narangua, a staff member of the Wildlife Conservation and Study Center (WCS), was invited to teach a SMART program course for the intermediate level of qualification training. By the request of the Khustain National Park Conservation Administration, the course was expanded to include 7 additional rangers.

Combining the training with lectures and practices, 30% of the lesson was theory and 70% -was practice and lasted 5 days. The training was conducted using various photographic equipment, 200-400 mm photo telescopes, 3 sets of automatic photographic cameras, maps of various scales, telescopes, 3 GPS units, 2 rangefinders, compasses, live traps, 3 collars with radio transmitters of various sizes, compasses, DJI Mavic pro model unmanned aerial vehicles (UAVs), herbariums of plants, and various video recordings.

Nine rangers participated in the First level qualification training and six in the intermediate level training, and nine instructors taught the courses. At the end of the training, the rangers were awarded a certificate of completion signed by the State Secretary of the Ministry of Environment and Climate Change.

**Monitoring of the training process**. The training process and activities were attended by Dr. P. Galragchaa, Senior Advisor of the Biodiversity Conservation and Climate Change Adaptation Project, M. Amgalan, Contract Specialist, and Dr. S. Bayarkhuu, Executive Director of the Mongolian Ranger Federation. They represented the action group of the Ministry of Environment and Climate Change, and they provided with some suggestions and recommendations.

From the executors, it is considered that the training was conducted without any mistakes following the pre-arranged lesson plan and with high level.

**Training materials**. In addition to practical materials such as pictures, diagrams, printed sheets, videos, slides, various tools, equipment, and collection of herbariums, a total of 31 thematic digital materials (first level-15, intermediate level-16) was prepared and used for each chapter and topic. These materials were delivered to the project unit in the original form digitally.

**Assessment of training gain and progress.** A test made in advance was used to check the knowledge of the trainees at the beginning and then at the end of the training and to assess their progress. The 9 rangers of the first level training answered 102 questions out of 270 questions correctly at the beginning, which was 37.8%, but after the training they answered 150 questions correctly, which was 55.6%, and their knowledge level increased by 17.8 percent. The 6 rangers in the intermediate training answered 107 questions out of 180

questions correctly at the beginning, which was 59.8%, but after the training they answered 125 questions correctly, which was 69.4%, and their knowledge level increased by 10 percent.

**Opinions and conclusions about the training from the rangers.** A satisfaction survey was conducted with 15 rangers who participated in the first and intermediate level training, as well as 5 rangers from Khustai National Park. When asked about the teachers' skills, lesson preparation, materials, and communication with students, they were rated as excellent 45 times and good 35 times (Figure 1).




Teachers' skills assessment

1.The use of materials 2.if the answers were effective 3.teaching method and skill to make understand 4.Communication and attitude

Figure 1.Evaluation of Trainers

In a survey regarding to the achievement of training objectives and the demand for subject content, 19 participants rated the training as good or excellent, and 1 participant rated it as unsatisfactory (Figure 2).

According to the results of a survey regarding to the duration of training, 90% of the participants considered the duration of the training to be appropriate, 5% considered it as too short, and 5% considered it as too long (Figure 3).




Fugure 2.Satisfactory rating
If the training fulfills the aim
If the content of the unit and the topic meets the demand




Figure 3.Duration of the training
Too short
Acceptable
Too long

**Other notification**

1. Total of 30 people including trainees and rangers of the Khustain National Park were provided basic health check-up by S. Davaatseren, the senior expert in the finance and logistics department of The Front Office of Emergency Situations, captain of the emergency services, medical doctor, Master of medicine.
2. This medical check-up resulted that 86.6 percent of the rangers had abnormal heart and vascular function indicators and high blood pressure (140/100mmHg – 180/120mmHg), which we hope it would be taken into account by the relevant authorities.

**CONCLUSION**

1. The program content of the first and intermediated level qualification training for rangers is fully needed to the meets of the rangers and results in their furthermore functions.
2. The program content of the first and intermediate level qualification training fully corresponds to the planned time frame.
3. We believe that the training modules developed by the implementation team in accordance with the content of the first and intermediate level qualification training programs fully meet the training requirements.
4. According to the results of the satisfactory rating received from the trainees, 95 percent of them assessed that the training met its objectives and was effective, which is a realistic assessment of the work of the implementation team.
5. The knowledge level of the participants in the training increased by 27.8 percent compared to the previous training period, and it is considered that there has been a certain progress and advancement as one of the results of this monitoring training.
6. Organizing the training for qualification of rangers with the group of 15-20 people will be more effective.

## RECOMMENDATION

We consider that it is appropriate to correct and improve some of the points noted during the development of the training manual and the organization of the monitoring training. These include:

1. In the 1st level qualification training program, Part 3, the chapter “Safety and first aid” the topic of “First aid for heart attack and stroke” should be renamed to “First aid for blood pressure and stroke”. We organized the monitoring training under this name and also included it in the training manual.
2. 16-hour SMART methodology course was taught in the intermediate level on experiment basis and as a result we consider that the following amendments should be included in the training program. For example, SMART methodology was developed for the personnels with two different functions: security service specialist of the Specially Protected Area and rangers. So, it is necessary to organize the training of SMART methodology with two separate and different contents according to their functions, in the future. Accordingly, it is proposed to remove the part for specialists from the SMART methodology content and study the content for 14 hours.
3. Since rangers are responsible for applying the SMART methodology in their daily activities and enforcing the law from the moment they start working, it is necessary to explore the possibility of incorporating this content into the content of the First level qualification training.
